



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг бар

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2024.07.23 № 596

танай _____ -ны № _____ -т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХЭНТИЙ
АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНД

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд Г
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Хэнтий аймгийн Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай

232420625

хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт


Хэнтий аймгийн Монгол ардын намын хорооны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хэнтий аймгийн Монгол ардын намын хорооны мөрийн хөтөлбөр (13 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хэнтий аймгийн сонгуулийн хороонд.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /Ж.ГАНБААТАР/

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР  /Д.ОЮУНТУЯА/

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР  /Ц.БИЛЭГСАЙХАН/

АУДИТОР  /Ц.ХАТАНБОЛД/



**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХЭНТИЙ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



ХЭНТИЙ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН 2024 ОНЫ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

АГУУЛГА.

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН
БОДЛОГО

1.1. Орон сууц	6
1.2. Эрүүл мэнд	9
1.3. Боловсрол	20
1.4. Халамж, хөдөлмөр эрхлэлт	10
1.5. Үндэсний бахархал, өв соёл, спорт	7
1.6. Хүүхэд гэр бүлийн хөгжил	4

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Хөдөө аж ахуй	9
2.2. Аялал жуулчлал	8
2.3. Дэд бүтцийн сүлжээ	
2.3.1. Эрчим хүчний төсөл	7
2.3.2. Агаарын тээвэр	2
2.3.3. Авто зам	4

ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2317144297
СНУА0046 9074082

ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО- 12

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО



НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Орон сууц

1.1.1. “Хэнтий Орон Сууц” ОНӨҮГ-аар дамжуулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд олон төрлийн /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон, хямд өртөгтэй/ орон сууцны хангамжийг аймгийн хэмжээнд нэмэгдүүлнэ.

1.1.2. Орон сууцны төлөвлөлтөд сургууль, цэцэрлэг, ногоон байгууламж, усан оргилуур, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэх стандарт хэрэгжүүлнэ

1.1.3. “Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд түрээсийн орон сууц барих ажлыг бодлогоор дэмжиж аймаг, сумдын иргэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд төрийн бодлоготой уялдуулан ажиллана.

1.1.4. Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, засварлахад хөнгөлөлттэй зээл олгох ажлыг боломжийг судлан хэрэгжүүлнэ.

1.1.5. “Миний ажилтан орон сууцтай” хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчид болон ажилтандаа орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлсэн хувийн хэвшлийн ААН-үүдэд хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

1.1.6. Зорилтот бүлэг /төрийн албан хаагч, залуу гэр бүл/-д чиглэсэн орон сууцны төслийг хэрэгжүүлж, урьдчилгаа төлбөрийн батлан даалт, ипотекийн зээлийн асуудлыг шийдвэрлэнэ.

1.2. Эрүүл мэнд

1.2.1. Орон нутагт дутагдалтай байгаа эмч, мэргэжилтнийг бэлтгэх бодлогыг тодорхойлж, тэднийг чадавхжуулах, хүний нөөцийн нийгмийн баталгааг ханган ажиллана.



1.2.2. Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл мэндийн үзлэгийг тасралтгүй үргэлжлүүлж, дундаж наслалтын хүйсийн ялгаатай байдлыг багасгах бодлого хэрэгжүүлнэ.

1.2.3. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, сануулах хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэн эрт илрүүлгийг нэмэгдүүлнэ.

1.2.4. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчнөөс урьдчилсан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ.

1.2.5. Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношилж, эмчлэх чиглэлээр гадаадын эмнэлгүүдтэй гэрээ байгуулж, хамтарч ажиллан аймгийнхаа иргэдэд ээлтэй тогтолцоог бий болгоно.

1.2.6. Монгол улсын хэмжээнд 3000 эмч, 10000 сувилагч, 500 мэргэшсэн асрахуйн ажилтан гадаад, дотоодод бэлтгэх бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хүний нөөцийг чадавхжуулах арга хэмжээг чиглэл бүрээр зохион байгуулж, ур чадварыг нэмэгдүүлэх, гадаад болон дотоодод туршлага судлуулна.

1.2.7. “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг орон нутагт үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.8. Эрүүл мэндийн байгууллагуудыг стандартын шаардлага хангасан авто машинаар үе шаттайгаар хангана.

1.2.9. Цэнхэрмандал сум, Бэрх хотын эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, Хэрлэн суманд Жишиг өрхийн эмнэлэг барьж ашиглалтад оруулна.

1.3. Боловсрол

1.3.1. Хэрлэн суманд 120 хүүхдийн яслийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулан 1-2 хүртэлх насны хүүхдийг яслийн үйлчилгээнд хамруулна.

1.3.2. Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ.



1.3.3. Бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлж, сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлж, хүүхдийн өөрийнх нь авьяаст тулгуурлан хүүхдийг хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.

1.3.4. Нүүдлийн соёлын чадавхыг ерөнхий боловсролын сургалтаар өгөх, бэхжүүлэх хүрээнд биеийн тамирын хичээлийн агуулгад үндэсний бөх, технологийн хичээлд хатгамал, дээл оёх, хөгжмийн хичээлд уртын дуу, морин хуур, биелгээг оруулна.

1.3.5. Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

1.3.6. Зарим сургуулиудад байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори, туршилтын талбай байгуулна.

1.3.7. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн болон хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулан хэрэгжүүлнэ.

1.3.8. Шаардлагатай сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулж зориулалтын тоног төхөөрөмжөөр хангана.

1.3.9. Хэрлэн суманд Боловсролын хөгжлийн төвийн барилгыг барьж байгуулна.

1.3.10. Цэцэрлэг, сургуулийн орчныг камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

1.3.11. Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгож, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

1.3.12.. Хэрлэн сумын Тэмүүжин сургуулийн бага сургуулийн барилгыг буулгаж, шинээр 960 хүүхдийн хичээлийн байр барьж ашиглалтад оруулна

1.3.13. Батноров сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг барьж дуусган ашиглалтад оруулж, Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-Улаан тосгонд 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг барина.



1.3.14. Дархан сумын 320 хүүхдийн сургуулийн барилга, Баян-Овоо сумын сургуулийн спорт заалны барилга, Баянмөнх, Галшар, Дадал сумын Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны барилгын өргөтгөл, Хэрлэн сумын Хан Хэнтий сургуулийн урлаг заал, гал тогооны барилгын өргөтгөлийг барьж байгуулна.

1.3.15. Цэнхэрмандал, Дархан, Биндэр суманд 100 ортой хүүхдийн дотуур байр, Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн 160 ортой хүүхдийн дотуур байр, 4, 5 дугаар сургуулийн 100 ортой хүүхдийн дотуур байрыг шинээр барьж ашиглалтад оруулна

1.3.16. Ахлах сургуулийн хэв шинжид 1-2 сургуулийг бүрэн шилжүүлнэ.

1.3.17. Цэцэрлэгийн хоол болон Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны стандартыг шинэчилж, орц найрлагыг нэмэгдүүлэх, амин дэмээр баялаг хоол, сүү сүүн бүтээгдэхүүнээр үйлчилнэ.

1.3.18. Багшийн хөгжилд дэмжлэг үзүүлэх сургалт, арга зүйн байгууллагуудын чадавхийг дээшлүүлж, үйл ажиллагааг өргөтгөн багш бэлтгэдэг их дээд сургуулиудтай хамтран ажиллах үйл ажиллагааг дэмжинэ.

1.3.19. Дэлгэрхаан суманд байгуулж байгаа аймгийн багш нарын амралт сувилалын газрыг дуусган ашиглалтад оруулж, хувийн үйл ажиллагааг хангана.

1.3.20. Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3-ийг хэрэгжүүлэхэд орон нутгаас санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

1.4. Халамж, хөдөлмөр эрхлэлт

1.4.1. Иргэдийг хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжлээр мэргэжлийн сургалтад хамруулан бүтээмжтэй, зохистой ажлын байрыг бий болгох замаар, хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ажилтай, орлоготой болгож, ядуурлын түвшинг бууруулна.

1.4.2. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулж, оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг дэмжиж хөгжүүлнэ.

1.4.3. Ахмадын аймгийн аварга шалгаруулах спортын тэмцээнийг нэрэмжит болгон төрлийг нэмэгдүүлнэ



1.4.4. Төрийн байгууллагуудын нэрэмжит Ахмадын өдөрлөгийг уламжлал болгон явуулна.

1.4.5. Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулна

1.4.6. Тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлсэн тохируулгатай ажлын байр бий болгосон жишиг байгууллага, аж ахуйн нэгжийг жил бүр шалгаруулна.

1.4.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгэмд дасан зохицох, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш хамрагдах, бие даан амьдрах, хөгжих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Хүний хөгжлийн төв”- ийг ажиллуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

1.4.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад 100 хувь мөрдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.

1.4.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

1.4.10. Гарааны бизнес эрхлэгч оюутан, залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.5. Үндэсний бахархал, өв соёл, спорт

1.5.1. Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалтыг сайжруулна.

СЮА0046 9074082

1.5.2. Үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна.

1.5.3. Бор-Өндөр, Хэрлэн суманд Залуучуудын сургалт, спорт хөгжлийн төвийг барьж байгуулна

1.5.4. Цэнхэрмандал, Батширээт сумын соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулна.



1.5.5. Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, хөдөлгөөнт дасгал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

1.5.6. Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх тогтолцоог сайжруулж, мэргэжлийн тамирчдын аймаг, бүс, улсын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.

1.5.7. Баян-Адрага, Норовлин, Дархан, Өмнөдэлгэр сумын Гурванбаян тосгонд спорт заал барьж байгуулна.

1.6. Хүүхэд, гэр бүлийн хөгжил

1.6.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх аймгийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.6.2. Хүүхэд гэр бүлд үзүүлэх хөгжлийн үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэн, нийт хүүхэд гэр бүлийн 50 хувьд үйлчилгээ үзүүлнэ.

1.6.3. Гэр бүл, хүүхэд сургалт хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг сургалтын баазтай болно

1.6.4. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ

ХОЁР ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Хөдөө аж ахуй

2.1.1. Малын гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхлэх загвар хоршоодод дэмжлэг үзүүлнэ.144297
СЮА0046 9074082

2.1.2. Мал амьтнаас хүнд халдварладаг халдварт өвчний хяналт, сэргийлэлт, яаралтай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах дэд төвийг байгуулна

2.1.3. Малын тоог чанарт шилжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг дэмжих, "Монгол мал-II" арга хэмжээг аймагтаа хэрэгжүүлнэ.

2.1.4. Усалгаатай газар тариаланг хөгжүүлэн үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн хэрэгцээг бүрэн хангаж бүсдээ болон бусад бүсд нийлүүлнэ.

2.1.5. Мал төхөөрөх бага оврын үйлдвэрийг Галшар суманд барьж байгуулна



2.1.6. Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр салбар дундын дадлагын баазыг байгуулна.

2.1.7. “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж, хоршоолохыг дэмжинэ.

2.1.8. Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, ажлын байрыг сум бүрт нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.1.9. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.

2.2. Аялал жуулчлал

2.2.1. Хар зүрхний Хөх нуурын аялал жуулчлалын бүс нутгийг төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбоно.

2.2.2. Цэнгэлдэх хүрээлэнгийн урд талд амралт, аялал жуулчлалын гудамж байгуулна.

2.2.3. Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуу түр буудаллах цэгүүдийг Цэнхэрмандал сумын Хэрлэнгийн гүүр, Өмнөдэлгэр, Батноров, Норовлин, Дэлгэрхаан сумдад байгуулна.

2.2.4. Аялал жуулчлалын гол маршрут дагуу сумдад отоглох цэгийг Дадал, Биндэр, Баян-Адарга, Батширээт, Норовлин, Батноров сумдад бий болгоно.

2.2.5. Чингис хааны өлгий нутаг, түүх, соёлын нөөц, экосистемд түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна

2.2.6. Баян-Адрага сумын Дуурлиг нарсны дурсгалт газрын мэдээлэлийн төвийг барьж байгуулна

2.2.7. Аялал жуулчлалын ач холбогдол бүхий газруудыг google map дээр байршуулах мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана

2.2.8. Нутгийн иргэдэд түшиглэсэн, нүүдэлчин соёлыг харуулсан аялал жуулчлалыг хөгжүүлэх, чадавхижуулах, бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлнэ.

2.3. Дэд бүтцийн сүлжээ

2.3.1. Эрчим хүчний төсөл



2.3.1.1. Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцыг ашиглалтад оруулж, дулаан хангамж, дэд бүтэц байгуулна.

2.3.1.2. Багануур–Чингис–Чойбалсан 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, эрчим хүчний тасалдлыг арилгана.

2.3.1.3. Зүүн бүсэд 100 доошгүй МВА чадалтай сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд бий болгох талаар Хэрлэн, Онон голуудад бага чадлын усан цахилгааны станцын боломж судлах, Салхины хурд эрчимжилтийн судалгаа хийнэ.

2.3.1.4. Хэрлэн сумын 2 дугаар багт 2500кВА чадалтай 35/6 кВ-ын дэд станц барих, Баянмөнх сумын төвийн 10кВ, 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчилнэ.

2.3.1.5. Хэнтий-ЦТСС-ын хэрэглэгчдэд үйлчлэх төвийн барилгын барьж ашиглалтад оруулна

2.3.1.6. Хэрлэн сумын шинэ суурьшлын бүсэд цахилгаан дамжуулах шугам татах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, суурьшлын бүсийг тэлэх бодлого хэрэгжүүлнэ.

2.3.1.7. Сумдын гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчныг бүрдүүлнэ.

2.3.2. Агаарын тээвэр

2.3.2.1. Дэлүүн болдог нисэх онгоцны буудлаас Дадал сумын төв хүртэл 8 км хатуу хучилттай авто замын барих төслийг хэрэгжүүлнэ.

2.3.2.2. Өндөрхаан нисэх онгоцны буудлыг ашиглалтад оруулж, нисэх буудлаас аймгийн төв хүртэл 2.9 км хатуу хучилттай авто зам барина.

2.3.3. Автозам

2.3.3.1. Аймгийн төвөөс Норовлин сум хүртэлх автозам, Жаргалтхаанаас Өмнөдэлгэр сум хүртэлх хатуу хучилттай зам, Бэрх хотын доторх 4.1 км хатуу хучилттай зам, Хэрлэн сумын 6-р багаас Хэрлэн гол хүртэлх 14,2 км авто зам, Хэрлэн голын 265 у/м төмөрбетон гүүрийг барьж дуусган ашиглалтад оруулна.

2.3.3.2. Жаргалтхаан-Дэлгэрхаан чиглэлийн хатуу хучилттай авто зам, Бор-Өндөр- Дархан- Баянмөнх- Чингис хот чиглэлийн хатуу хучилттай авто зам,,



Өмнөдэлгэр сумаас Биндэр, Баян-Адрага чиглэлийн автозам, Баян-Овоо-Түмэнцогт чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулна.

2.3.3.3. Дархан, Баянмөнх, Биндэр, Норовлин, Цэнхэрмандал, Дэлгэрхаан сумын доторх автозамыг хатуу хучилттай болгоно.

2.3.3.4. Чингис хот доторх хуучин авто замын сүлжээг өргөтгөн шинэчлэх, ус зайлуулах байгууламжийг нэмэгдүүлнэ.

ГУРАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3.1. Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэн, хот, суурин газрууд хог хаягдлын зориулалтын байгууламжтай болно. /Чингис хотод I зэргийн, Биндэр, Бор-Өндөр, Өмнөдэлгэр, Баян-Овоо сумдад II зэргийн, бусад сумдад (Дадалаас бусад) III зэргийн ландфил байгууламж /

3.2. Хог хаягдал ангилан ялгах цехийг байгуулна.

3.3. Эвдрэлд орсон, бохирдсон газрыг нөхөн сэргээх, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлж, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ

3.4. Жил бүр 3-5 сая мод тарих замаар ойн сан, хамгаалалтын ойн зурвасыг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулж "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангана.

3.5. Уул уурхайд үйлдвэрлэлийн технологи болон автомашин угаалгын газрын хэрэглэсэн усыг дахин ашиглах, саарал ус нийлүүлэх төслийг дэмжинэ.

СЮА0046 9074082

ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1. Хэрлэн суманд Шүүхийн шинжилгээний хэлтсийн албан конторын барилга, Гал түймэр унтраах, аврах ангийн 1 дүгээр зэрэглэлийн барилга, Бор-Өндөр суманд Гал түймэр унтраах, аврах ангийн 3 дугаар зэрэглэлийн барилга, Дадал суманд Хилийн цэргийн 0287 дугаар ангийн Штабын барилгыг барина.



4.2. Зайлшгүй шаардлагатай асуудлаар хяналт шалгалт хийх "НЭЭЛТТЭЙ СОНСГОЛ"-ыг тогтмол зохион байгуулж иргэдийн мэдэх эрхийг хангана.

4.3. Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.

4.4. Багш, эмч, төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.

4.5. Төрийн түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлж, гурваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдын цалин хөлсөнд нийцсэн ипотекийн зээл олгох бодлого баримтална.

4.6. Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

4.7. Тендер сонгон шалгаруулалт, газар олголт, орон нутгийн эд хөрөнгийн дуудлага худалдааг ил тод нээлттэй зохион байгуулах, асуудал маргаангүй шийдвэрлэх бүх боломжийг бий болгох, хариуцлагажуулна.

4.8. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах "Асуудлаас шийдэлд" дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

4.9. Аймаг орон нутагт шаардлагатай байгаа боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор "Зөгийн үүр" арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.10. Орон нутгийн төсвөөс санхүүждэг төрийн байгууллагад ажиллагсдад төсвийн боломжид тулгуурлан орон нутгийн нэмэгдлийг нэмэгдүүлэн олгоно.

4.11. Бүх сумын төвд камержуулалтын системийг бүрэн нэвтрүүлнэ.

4.12. Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулж, иргэд, бизнест төвөггүй, хялбар үйлчилгээг үзүүлнэ.

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1. Хэрлэн сумын 3,4,5 дугаар баг, Дэлгэрхаан, Дархан, Баян-Адрага сумын гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбоно

5.2. Хэрлэн суманд Цэвэр усны эх үүсвэрийн худаг шинээр гаргах, нөөцийн сан байгуулна.



5.3. Ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, цэвэр усан хангамж, усан сангийн байгууламжийг Батширээт, Жаргалтхаан суманд, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийг Мөрөн, Өмнөдэлгэр суманд тус тус барьж байгуулна.

5.4. Норовлин, Баян- Овоо, Галшар, Мөрөн, Батноров, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дэлгэрхаан, Дархан, Баянмөнх, Баянхутаг сумдад үүрэн телефоныг сүлжээг өргөтгөнө.

5.5. Бэрх хотод Үерийн ус зайлуулах системийг байгуулна

5.6. Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын тогтолцоог хөгжүүлж, алслагдсан бүс нутаг, аймгийн төв, сумдад томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.

5.7. Баянхутаг, Өмнөдэлгэр, Жаргалтхаан, Дэлгэрхаан, Батширээт суманд Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийг барьж байгуулна. Баян-Овоо сумын төвийг барьж дуусгана

5.8. Жишиг гудамж төслийг аймаг, сумдын төвийн багуудад үе шаттайгаар нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна

5.9. Суурин газруудад байгаа хуучирч муудсан, эзэмшил нь тодорхойгүй, иргэд олон нийтийн аюулгүй амгалан байдалд сөргөөр нөлөөлөхүйц барилга байгууламжийг тогтоон газрыг чөлөөлүүлэх, буулгах, шинээр бүтээн босгож эдийн засаг, нийгмийн эргэлтэд оруулна

2317144297
CPOA0046 9074082

5.10. Аймгийн төв болон сумын цэвэр усны худгийг ухаалаг системд үе шаттайгаар шилжүүлнэ.

5.11. Төрийн байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, бүртгэл, хамгаалалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, холбогдох арга хэмжээ, хариуцлага тооцож ажиллана.

